

протекционист бодлого хэрэгжүүлэх;

- Дээрх арга хэмжээний хүрээнд нэн тэргүүнд төрөөс өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй эх орны үйлдвэрүүдэд өмчийн хэлбэр харгалзахгүй захиргааны болон захиргааны бус дэмжлэг, туслалцаа үзүүлэх, татаас олгох, татварын болон зээлийн хөнгөлөлт үзүүлэх замаар экспортыг урашуулах, импортыг оновчтой уян хатан үе шаттай хязгаарлах (тарифын болон тарифын бус хязгаарлалт, олон зорилго чиглэлтэй стандартууд, лиценз, квотууд) тогтоох шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Joseph E. Stiglitz, Globalization and it's discontents. 2003.
2. Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.nso.mn>
3. Үндэсний статистикийн хорооны мал тооллогын 2017 оны урьдчилсан дүн, <https://www.nso.mn>
4. Монгол банкны мэдээллийн нэгдсэн сайт, <https://www.mongolbank.mn/>
5. Дэлхийн Банкны ядуурлын судалгааны тайлан, <http://www.worldbank.org/mn/news/press-release/2017/10/17/2016-poverty-rate-in-mongolia-estimated-at-296-percent>
6. Үндэсний статистикийн хорооны 2017 оны 12 сарын товхимол, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, <https://www.nso.mn>

АЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАРЫН ТУХАЙД БОДРОЛ

A Some Thought Regarding Asian Development Model

Др.проф. Д.Уламбаяр¹
ulambayar@humanities.mn

ХӨГЖЛИЙН МОДЕЛИЙН ТУХАЙД

Хүн төрөлхтөн өнөөгийн ирмүүн хөгжлийн өндөрлөгт тулж ирэхдээ улс төр-эдийн засаг, нийгмийн хөгжлийн үр ашиг бүхий хэд хэдэн загварыг буй болгож бүтээн байгуулж иржээ.

Нэг дэх нь Өрнө дахиний хөгжингүй орнуудын эдийн засгийн хөгжлийн загвар даруй мөн бөгөөд энэ нь 1640 оны Английн Хөрөнгөтний аугаа их хувьсгалаар гараагаа эхэлж, 1760-1820 онд өрнөсөн аж үйлдвэрийн хувьсгал, 1776 оны Америкийн Тусгаар тогтнолын Тунхаглал, 1787 оны Америкийн Анхдугаар Үндсэн хууль, 1789 оны Францын Хөрөнгөтний их хувьсгал, түүний үр дүнд батлагдсан Хүн ба Иргэний Эрхийн Тунхаглал, 1791 оны АНУ-ын Эрхзүйн Тунхаглал, 1865 онд Америкийн иргэнийн дайны үр дүнд боолчлолыг ялсан Хөрөнгөтний хоёр дахь хувьсгалаар бэлтгэгдэж өнөөг хүрч ирсэн буюу *улс төрийн ардчилалыг хөгжүүлэх үндсэн дээр эдийн засгийн ардчилалыг хөгжүүлж ирсэн тэр загвар* юм. Сонгох, сонгогдох, үг хэлэх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, жагсаал цуглаан зохион байгуулах, өмч эзэмших, түүнийг захиран зарцуулах, бизнес эрхлэх, чөлөөтэй зорчих, шүүхэд дуудагдахад өмгөөлөл авах болон бусад хүний эн тэргүүний эрхийг хуульчилсан нь зах зээлийн эдийн засаг өөрийн жам ёсоороо хөгжин

¹ Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал

цэцэглэж эхлэх үүд хаалгыг нээжээ. Бараг 300 гаруй жилийн түүхэн хөгжлөөр бэлтгэгдэн буй болж, боловсронгуй болсоор иржээ. Үндсэндээ Англи, Америкийн хөгжлийн загвар гэж хэлж болно. Харилцан хамаарлаас шалтгаалцсан даяаршил хийгээд дижиталчлалын үйл явц, түүнийг манипуляц хийх үндсэн дээр зах зээлийн эдийн засаг дахь төрийн зохицуулалтыг зохих түвшинд хөгжүүлэх шаардлага буй харуулсаар байгаа болно.

Хоёр дахь гэж хэлж болох *Скандинавийн орнуудын социал-демократ хөгжлийн загвар бол нийгмийн хамгааллыг* төвдөө тавьж улс төр, эдийн засгийн ардчлалыг хос хөгжүүлж ирсэн явдал юм. Энэхүү загвар XIX зууны сүүлчээр үзэл санаа, онолын хувьд бэлтгэгдэж, дэлхийн II дайны дараа эрч хүчээ авч өнөөг хүрч ирсэн байна. Үүнд «Шведийн загвар»-ыг онцгойлон нэрлэх нь олонтой. Тус улсын хамгийн хүчтэй социал-демократ улс төрийн хүчин олон жилийн турш өөрчлөлтийн төлөө уйгагүй чармайж, энэ нь бодит амьдрал болж хувирчээ. Сайхь «загварын» орчин үеийн хэлбэрийг 1932 онд социал-демократууд Засгийн эрхэнд гарахдаа дэвшүүлснээс хойш багахан завсарлагатайгаар 70 гаруй жилийн туршид хэрэгжүүлж иржээ. Энэ хооронд үйлдвэрийн эзэд, хөрөнгөтнүүдийн хөндөж байгаагүй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах зорилтыг тэргүүн зэрэгт тавьснаараа олон түмэнд үнэлэгдэх болсон явдал юм. Энэ нь зөвхөн зорилго байсангүй, ажилчин ангийг бүхэлд нь идэвхжүүлж үйлдвэрчний эвлэл, зүүний хүчнийхэн, бүх хөдөлмөрчдийг хөдөлмөрт дуудсан уриалга байжээ. Мөн нийгмийг өөрчлөх эхний шатанд ажилгүйдлыг устгах зорилт тавьсан байна. Энэ зорилт хүн бүхнийг хөдөлмөрлөх эрхээр хангасны үндсэн дээр орчин үеийн үйлдвэрлэлийг удирдах өндөр мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэхэд оршиж байв. Үүний тулд парламент, үйлдвэрчний эвлэл, компаниудаас оролцсон төрийн байгууллагуудын төлөөлөгчдийн хамтарч боловсруулсан тусгай хөтөлбөрт ажлын байр буй болгох, шинээр ашигтай, ирээдүйтэй үйлдвэрүүдийг нээх, түүнд мэргэшилтэй ажилчдийг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан бэлтгэх, шинэ мэргэжлээр сургалтад хамруулах асуудлыг тусгаж байжээ. Энэ бодлогын үр дүнд 1970-80-аад оны эрчим хүчний хямралын үед ч Шведэд ажилгүйдэл 1,5 хувиас хэтрээгүй байна. Шведийн улс төрийн тогтолцооны онцлог

нь төвлөрөн удирдах ёс бүхий ардчилсан нийгмийн бүтэц байв. Улс төрийн аливаа маргаантай асуудалд социал-демократ нам бусад либерал намуудын хооронд харилцан ойлголцож тохиролцох, буулт хийж бие биеэ харилцан хүндэтгэх, мөн эрх баригч нам, төрийн сайд дарга нар сөрөг хүчнийхэнтэй хэлэлцээ хийх замаар асуудалд ханддаг байжээ. Энэ нь тус улсын хүн амын санаа бодлыг төрийн хэрэгт тусгадгийн тодорхой жишээ болсон юм. «Өгөөмөр төр» гэдэг нэр томьёо гарсан нь нийгмийн зүгээс хүн амд үзүүлэх тусламж төдийгүй иргэний нийгмийн хамгааллын цогцолбор хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан явдал болно. Үүгээрээ ч Швед улс дэлхийд дээгүүр байранд ордог агаад төр, засаг нь хүнийг «өлгийтэйгээс нь булшинд ортол тэжээдэг» гэсэн үг ч гарчээ. «Өгөөмөр төр»-д эрүүлийг хамгаалах, боловсрол олгох, нийгмийн даатгал төдийгүй тэтгэврийн асуудал багтаж байв. Тэгэхдээ хүүхэд, хөгшчүүлд харьцангуйгаар илүү анхаарал халамж тавьж байсны жишээ нь үнэгүй өглөөний цай өгөх, хичээлийн сурах бичгээр хангах, төрөл төрөгсөдөд нь эд материалын тусламж үзүүлэх зэргийг нэрлэж болно. Настангуудад хоёроос дээш тэтгэвэр олгодог байсан бөгөөд эхнийх нь өндөр насны тэтгэвэр, харин хоёр дахь нь ажилласан жилд нь олгох тэтгэвэр байжээ. Ингээд тэд урьд ажиллаж байсныхаа цалингийн 80 хувийг тэтгэвэрийн замаар авах боломжтой болсон байна.

Норвеги улс ЕХ-ны гишүүн бус ЕЧХН-ийн гишүүн (Швейцарь, Лихтенштейн, Исланд гишүүнчлэлтэй) бөгөөд 4.9 сая хүн амтай, ДНБ-нийхээ 1.09 хувийг хөгжлийн тусламжид зориулдаг, НҮБ-ын хөгжлийн тусламжийн хөтөлбөрүүдэд оруулдаг хандиваараа дэлхийд 10 дугаар байранд ордог, 2017 оны байдлаар хөгжлийн албан ёсны тусламжид 4. тэрбум ам. доллар зарцуулжээ.² Олон улсын санхүүгийн зах зээлд үнэлгээ хийдэг *Standart & Poor's* компаний итгэлцүүрээр гадаад, дотоод зээлжих зэрэглэл тогтмол +AAA үнэлгээтэй, Засгийн газрын төсөв жил дараалан 40.9 тэрбум ам. долларын ашигтай гарч ирсэн байх агаад НҮБ-ын Хүний хөгжлийн индексээр дэлхийд тэргүүн байранд орж байна. Сүүлийн жилүүдэд гадаад худалдааны ашиг 80 тэрбум ам. долларт хэлбэлзэж байв. Норвегийн ДНБ-ний нэг хүн амд ногдох

² <https://www.oecd.org/dac/financing-sustainable-development/development-finance-data/ODA-2016-complete-data-tables>.

хэмжээ номинал үнэлгээгээр 2017 онд 73.4 мянган ам. доллараар Катар, Лихтенштейний дараа гуравт жагсаж, дэлхийн хамгийн өндөр хөгжил, тэгш хангалуун амьдралтай улсуудын тоонд хэдийн орсон бөгөөд уг сурвалж нь байгалийн баялагаас олж буй орлогоо хэрхэн зөв, зохистой ашиглаж байгаад оршино. Норвеги улс 1971 оноос Свальбард болон Шпицберген арлын орчим, Баренцын тэнгисээс сайн чанарын (brent crude) газрын тос, байгалийн хий олборлож эхэлсэн нь тус улсын эдийн засгийн гол салбар болж, улмаар тус улс газрын тос, хийн олборлолтоороо дэлхийд тэргүүлэх болж, хийн олборлолтоороо 3 дугаар байранд, газрын тосны экспортын хэмжээгээрээ ОХУ, Саудын Арабын дараа дэлхийд 3 дугаарт орох болжээ. 39 орон гарын үсэг зурсан 1920 оны Свальбардын гэрээгээр энэ нутаг Норвегийн мэдэлд орж, 1977 оны Баренцын тэнгисийн талаарх Норвеги-ЗХУ-ын гэрээгээр улам баталгаажсан байна. 2017 оны байдлаар газрын тос Норвегийн нийт экспортын 25.5 хувь, хийн 23.1 хувийг эзэлж, ДНБ-ний 14 хувь, Засгийн газрын төсвийн 30 хувийг бүрдүүлж байна.

Газрын тос, байгалийн хийнээс олж буй орлогыг зохицуулах “Засгийн газрын тосны сан”, “Үндэсний даатгалын сан”-г Норвеги улс 1990 онд байгуулсан бөгөөд 2006 оноос Засгийн газар уг сангийн дүрэмд өөрчлөлт оруулж, дээрх хоёр санг нэгтгэн “Засгийн газрын баялагийн сан” байгуулж, нийгмийн халамжийн зориулалтаар ашиглаж эхлэв. Үүнээс гадна сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг олон улсын санхүүгийн зах зээл дээр байршуулснаар Европт бүртгэгдсэн нийт хувьцааны 1.25 хувь, дэлхийд арилжаалагдсан хувьцааны 1 хувийг эзэмшиж буй ажээ. Арабын Нэгдсэн Эмиратын байгалийн баялагийн орлогоос бүрддэг төрийн эзэмшлийн «*Abu Dhabi*» хөрөнгө оруулалтын агентлаг 828 тэрбум ам. долларын хөрөнгөтэйгөөр Норвегийн сангийн дараа хоёрт орж байна.³ Норвегийн Засгийн газар газрын тос, байгалийн хийн баялгаас олсон ашгаас бүрдсэн “Засгийн газрын баялагийн сан”-гаар дамжуулан *жил бүр* ард иргэддээ тэгш хуваарилсаар ирэв.

Норвеги улс газрын тос, байгалийн хийгээс олсон орлогоо зөв менежментээр удирдсаны ачаар баялгийн сангийн нөөцийн хөрөнгийг алсдаа иргэн бүрт нэг сая ам. доллар оногдуулсантай тэнцэх хэмжээнд

3 Forbs statista. The Sovereign Wealth Fund Institute. September 19, 2017

хүргэх зорилт тавьж байна. 2017 оны 9 дүгээр сарын 19-нд Norges Bank Investment Management (Норвегийн Төв банк) сангийн гүйцэтгэх захирал Ингве Слингстад (Yngve Slyngstad) албан ёсоор мэдээлснээр баялгийн сангийн нөөц 7,851 их наяд норвеги крон болсон нь 1 их наяд ам. доллартай тэнцэж байгаа юм. Үүнийг Норвегийн бүх хүнд хуваавал хүүхэд тус бүрт \$200 мянган доллар ногдож байна.⁴ Норвегийн баялгийн сан хүн бүрт сая кроны хэмжээнд анх удаа хүрсэн нь бүр 2014 оны 1 дүгээр сар гэжээ. Түүнчлэн Норвегийн баялгийн сан нь 2017 онд ДНБ-ий 200 хувьтай тэнцсэн бөгөөд цаашид 2030 он гэхэд 220 хувьд хүрэх хандлагатай байгаа ажээ. Энэ бол байгалийн баялгаа хэрхэн зөв хуваарилдгийн гайхмаар бодит жишээ мөн. Үүнээс Норвегийн парламент жил бүр дөрвөн хувийг захиран зарцуулдаг байна. Гэхдээ Норвеги улс улам хөрөнгөжих тусам ард иргэдийнх нь хөдөлмөрлөх сонирхол буурч буй нь албаныхны санааг зовоох болсон байна. Албан ёсны судалгаагаар Норвегийн хөдөлмөрийн насны таван хүн тутмын нэг нь нийгмийн даатгалаас ямар нэгэн төрлийн мөнгөн тэтгэмж авч, гэртээ зүгээр суудаг байна.

2015 оны 5 дугаар сард Норвегийн парламент Ногоон намын шаардлагаар нүүрсний салбарт оруулсан хөрөнгө оруулалтаа татах шийдвэр гаргасан юм. 2015 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар баялагийн сан дэлхийд хамгийн алдартай 75 орны 122 үндэстэн дамнасан корпорациудын 70 тэрбум ам. доллараар хэмжигдэх бондыг худалдан авсан байна. Үүнд: Anglo American, BHP Billiton, Glencore, Pio Tinto, Shinhua зэрэг магнатуудыг нэрлэхэд хангалттай. Гол учир шалтгаан нь дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, Китогийн протоколыг хэрэгжүүлэх шаардлага, Парист 2015 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 11-ний хооронд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх саммитыг угтсан арга хэмжээ байв.

Ер нь Норвегид улсын сектор ихээхэн үр ашигтай ажилладаг, тиймээс ч хүчтэй байдаг ажгуу. Швед, Финланд, Данийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар ч дээрх орнуудтай ойролцоо байсан юм. Тиймээс төр муу менежер хэмээн сурталддаг нь пост-коммунист орнуудад ингэж ярьдаг ажгуу.

4 <http://www.businessinsider.com/norways-sovereign-wealth-fund-is-now-worth-a-trillion-us-dollars-2017-9>

Хөгжлийн *гурав дахь* загвар бол *Азийн шинээр аж үйлдвэржсэн* орнууд буюу «*Азийн бар*» хэмээн нэрлэгдэх болсон орнуудын эдийн засгийн хөгжлийн туршлага, загвар билээ. 1960-аад оноос хойшх гурван 10 жилд буй болгосон энэ загвар нь *эдийн засгийн ардчлалыг хөгжүүлэх үндсэн дээр улс төрийн ардчлалыг хөгжүүлж* ирсэн явдалд түүний мөн чанар оршиж байв. Азийн шинээр аж үйлдвэржсэн гэх Өмнөд Солонгос, Сингапур, Тайвань, Хон Конг зэрэг орнууд зах зээлийн эдийн засгийн тогтолцоог төрийн хүчтэй зохицуулалттай хослуулж, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлж иржээ. Үнэхээр ч сайхь орнууд олон жил колончлолд байж, дэлхийн II дайны дараа дундад зууны эдийн засгийн харилцаа гүн суурьтай байсан нь Өрнөдийн орнуудын ардчилалыг тэр чигээр нь хуулбарлан авах боломж, нөхцөлийг бүрдүүлээгүй юм. 1950-иад оны сүүлээр Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур сонгодог либерализм буюу америкийн загварыг туршсан боловч тэр нь хөгжлийг түргэтгэх гол хүчин зүйл биш гэдэг нь удалгүй харагдсан байна. Учир нь феодалын нийгмийн харилцаа, колоний системийн үлдэгдэл Өрнөдийн ардчилалыг шууд хуулбарлан нэвтрүүлэх боломжийг үгүйсгэж байсанд оршино.

Хэдийгээр цэргийн болон авторитар дэглэм эдийн засагт хүчтэй оролцож байсан боловч зах зээлийн бодит хуулиудыг үр ашигтай хэрэглэж, нээлттэй бодлого явуулж чадвал эдийн засгийн зохих өндөрлөгт хүрч болохыг энэ туршлага харуулсан юм. Хятад, Вьетнам ч коммунист намын удирдлагын дор зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж энэ нь ч үр дүнгээ өгсөөр байна. Чилийн хөгжлийн туршлага ч аанай л нэгэн адил юм. Нээлттэй эдийн засаг, экспортын чиглэлтэй бүтэц, гадаадын шууд хөрөнгө оруулалт, олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл, тусламж чухал хүчин зүйл болсон гэдэг нь өнөөдөр ойлгомжтой билээ. Нөгөө талд дурдсан орнууд коммунист Хойд Солонгос, эх газрын Хятадтай эдийн засгийн талаар уралдаж байсан явдал юм.

Азийн «шинээр аж үйлдвэржсэн» орнуудын нийтлэг шинж болсон хөгжлийн тодорхой үе шатуудыг дамжиж иржээ. Энэ нь *нэгд: 1960-аад онд импортыг орлох үйлдвэрлэлийг бүх талаар хөхиүлэн дэмжих, хоёрт, 1970-аад онд үйлдвэрлэлийн бүтцийг өөрчлөн хүнд үйлдвэр, экспортын чиг баримтласан үйлдвэрлэлийг*

түлхүү хөгжүүлэх, гуравт, 1980-аад оноос оюуны багтаамжтай өндөр технологи, цахим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэж иржээ. Харин дөрөвт, 1990-ээд оноос мэдээллийн технологийн салбарт дэлхийд тэргүүлэх байр суурь эзлэх явдал болов.

Нийгэм-эдийн засгийн хөгжлөөр доогуур түвшинтэй, хоцрогдсон Дорно дахины улс түмэн хөгжлөө хурдасгах бололцооны тухай үзэл баримтлал XIX зууны дундуур боловсрогджээ. Германы нэрт гүн ухаанч К.Маркс бээр сонгодог капитализмыг Английн эдийн засгийн жишээн дээр задлан шинжлэхийн хамт 1853 оны 8 дугаар сард Америкийн «*New York Daily Tribune*» сонинд анх удаа нийтлүүлсэн «*Энэтхэг дэх Их Британы эзэмшлийн ирээдүйн үр дүн*» хэмээх томоохон өгүүлэлдээ хоцрогдсон бага буурай орнуудыг нийгмийн хөгжлөө хурдасгаж тухайн үеийн өндөр хөгжилтэй Англи мэт орны хөгжлийн түвшинд ойртож, хөгжлийн замаа товчлоход Дорно дахины томоохон колони, хоцрогдсон орон болох Энэтхэгийг тусгайлан жишээ болгож, тус орон сайхь Англи шиг заавал бусдыг колончлон, цус балчигт живүүлж, ажиллах хүчнийг нь мөлжиж, эд баялагийг нь дээрэмдэн өөрийн аж үйлдвэрээ хөгжүүлж, капиталын хуримтлалыг буй болгосон тэр замыг сонгох албагүй гэж тэмдэглээд үүнийгээ К.Маркс зүйрлэхдээ: «*мөнхийн усыг хүртэхдээ заавал үхсэн хүний гавлын ясаар хийсэн аягаар уух албагүй, харин Английн хөрөнгөтнүүдийн үйлдвэрлэл эрхэлж байгаа арга, түүнийг зохион байгуулж байгаа тэр хэлбэрийг л ашигласан тохиолдолд эдгээр орнууд богино хугацаанд хөгжлийн зохих өндөрлөгт хүрч болно*» гэж үзжээ.

Харамсалтай нь хожим В.И.Ленин үүнийг мушган гуйвуулж, пролетарийн социалист хувьсгал ялсан орны тусламжтайгаар хоцрогдсон орнууд хөгжлийн тодорхой үе шатуудыг дамжин феодализмаас капитализмыг алгасан харайж коммунизмд шууд дэвшин орж болох «капиталист биш хөгжлийн замын» тухай «*онолын үндсийг боловсруулж*», түүнийгээ Зөвлөлтийн бүрэлдэхүүнд орсон Дундад Азийн орнуудад хэрэгжүүлж эхэлсэн билээ. Дэлхийн II дайны дараа

5 Karl Marx. "The Future Results of British Rule in India"- New York Daily Tribune. August 8, 1853

тусгаар орны хувьд БНМАУ капитализмыг алгасан феодализмаас социализмд шилжсэн орны «жинхэнэ биелэл» болж, шинээр тусгаар тогтнолоо олсон Ази, Африк, Латин Америкийн социалист чиг баримтлалтай орнуудад «түүхэн туршлага, хөгжлийн загвар, үзэл суртлын үлгэр дууриалал» болж байсан юм.

Геополитик, далайд гарцтай газарзүйн байршил нь олон улсын худалдаа-хөрөнгө оруулалттай интеграцчлагдах, цаг уурын тааламжтай нөхцөл байдал ургац хураалтад чухал дэм болсныг ч тэмдэглэх учиртай.

АНУ, Японы ашиг сонирхол Солонгосын дайны ид үед 1951 оны 9 дүгээр сарын 8-нд Сан-Франциско хотод Японтой энхийн гэрээ байгуулан, тусгаар тогтнолыг нь хүлээн зөвшөөрөх үйл явцыг түргэтгэсэн юм.

1953 оны 10 дугаар сарын 1-нд Вашингтон хотноо АНУ-БНСУ-ын хооронд Харилцан батлан хамгаалах гэрээнд Төрийн нарийн бичгийн дарга Жон Ф. Даллес, Гадаад хэргийн сайд Бён Ён-тэ (변영태) нар гарын үсэг зурж, 1954 оны 11 дүгээр сарын 18-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ.

Солонгосын дайн Хятадын БНУ буюу Тайваньд маш ашигтайгаар эргэсэн юм. Энэ дайнаас өмнө АНУ нь Тайвань болон эх газрын Хятад хоёрын мөргөлдөөнд ямар нэг байдлаар оролцохоос эрс татгалзаж, Тайванд дэмжлэг үзүүлэхээ зогсоогоод байсан билээ. Харин Солонгосын дайны дараанаас АНУ бүс нутагт өөрийн нөлөөллийг авч үлдэхийн тулд Тайванийн эрх баригчдыг бүх талаар дэмжих хэрэгтэй гэж үзэх болсон. Улмаар Тайвань руу өөрийн зэвсэгт хүчний ангиудыг илгээж, Chiang Kai-shek-ийн Хятадыг гарцаагүй ялагдлаас аварчээ. 1954 оны 12 дугаар сарын 2-нд Вашингтон хотноо АНУ-Хятадын БНУ-ын хооронд Харилцан батлан хамгаалах гэрээнд Төрийн нарийн бичгийн дарга Жон Ф. Даллес, Гадаад хэргийн сайд Жорж К.С. Йй (George Kung-chao Yeh) нар гарын үсэг зурж, гэрээ 1955 оны 3 дугаар сарын 3-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэллээ. Он 1960 оны 6 дугаар сарын 18-нд АНУ-ын Ерөнхийлөгч Дуайт Эйзенхауер Хятадын БНУ-ын тэргүүн Чан Кай-шигийн урилгаар анх удаа Тайбэйд түүхэн айлчлал хийсэн юм.

К. Марксын үзэл санаа жинхэнэ ёсоороо Дорно дахины шинээр аж үйлдвэржсэн «бар» хэмээх орнуудад биелэлээ олсон байна.

АЛС ДОРНО ДАХИНЫ ХОЁР ДАХЬ «ЯПОН»

1989 онд Солонгос гаралтай Японы судлаач Т.В.Канын бичсэн «*Is Korea the next Japan*» нэртэй бүтээл Нью-Йорк хотноо хэвлэгдэн гарсан нь нилээд дуулиан тарьсан юм. Уг нь Зүүн Ази, Номхон далайн хэсэг орон үйлдвэрлэлийн бүтцийг шинжлэх ухаан, технологийн үндсэн дээр шинэчилж, экспортын чиглэлтэй бодлого явуулснаар (үндсэндээ хөгжлийн Японы загвараар) эдийн засгийн өсөлтийг эрс хурдасгаж байгааг бүр 1975 онд Өрнөдийн стратегийн судалгааны нэртэй төвүүдийн дүн шинжилгээг үндэслэн Америкийн TIME сэтгүүл анхааруулан бичиж байжээ. Өнөөгийн Өмнөд Солонгос нь эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн урьд үзэгдээгүй ахицыг шинэ мянганы эхэнд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхитай орон гэж Өрнөдийн судлаачид тухайн үед тэмдэглэж байв. Үнэндээ Өрнөдийн судлаачдын зарим бүтээлд Өмнөд Солонгосыг «Алс Дорнодын хоёр дахь Япон» буюу «*Little Japan*» гэж томъёолсон нь буй.

1992 онд НҮБ-ын эвээл дор дээд хэмжээнд болсон Риогийн уулзалтын Тунхаглалыг хэрэгжүүлэх зорилгоор 1996 оны 4 дүгээр сард Солонгосын Хөгжлийн Хүрээлэнгээс эрхлэн Засгийн газар, эрдэмтэд, судалгааны томоохон хүрээлэн, үйлдвэр худалдааны бүлгийнхэн оролцсон *Think Tank* Солонгосын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал ба хөтөлбөрийг эцэслэн боловсруулж гаргасан юм. Энэхүү стратегийн зорилгоор Өмнөд Солонгос нь XXI зууны 20 он гэхэд эдийн засгийн хүчин чадавхиар 7-гийн бүлэгт баттай багтаж, ДНБ 4 их наяд доллар, худалдааны нийт эргэлт 2,44 их наяд долларт хүрнэ гэж тооцоолж байжээ. Энэ нь ДНБ-ээр дэлхийд долоо дахь, худалдаагаар зургаа дахь том гүрэн болно гэсэн үг байв. Урьдчилсан дүгнэлтээр инфляцийг 3 хувьд байлгаж, 2020 он гэхэд ДНБ-ий нэг хүнд оногдох хувийг 80,000 долларт (1995 оны үнээр) хүргэнэ гэжээ. Шинжлэх ухаан, технологийн чадавхиар ч 7-гийн бүлэгт нэгэнтэй багтаж аж үйлдвэрийн салбар дахь өндөр технологийн эзлэх хувь 13

хувь байсан бол 2020 онд 45 хувь болж өсөх ёстой гэж үзсэн ажээ. Судалгаанаас гаргасан илтгэлд ДНБ-ээр дэлхийд АНУ 26,9 их наядаар нэгд, 12,2 их наядаар Хятад хоёрт, 11,2 их наядаар Япон гуравт, 7,1 их наядаар Герман дөрөвт, 4,47 их наядаар Франц тавд, 4,4 их наядаар Итали зургаад, 4,0 их наядаар Өмнөд Солонгос долоо дахь байранд орно гэж үзсэн юм. Дэлхийн Банкнаас гаргасан илтгэлд 2020 онд Хятад, АНУ, Япон, Энэтхэг, Индонез, Германы дараа орж эдийн засгийн хүчин чадлаар дэлхийн долоо дахь гүрэн болно гэж урьдчилан дүгнэжээ. Энэ нь Өмнөд Солонгос Франц, Англи, Итали, Канадыг ардаа орхино гэсэн үг байв. Швейцарын Холбооны банкнаас гаргасан илтгэлд ч XXI зууны эхний 2 арван жилд Солонгос нь дэлхийн эдийн засагт гол хүчирхэг өрсөлдөгч арван орны нэг гэж үзсэн байна. Нэртэй төвүүдийн ойрмогхон тус тусдаа гаргасан дүгнэлтээс үзэхэд 2020 он гэхэд Солонгос нь эдийн засгийн чадавхиар 7 дахь гүрэн болно гэдгийг үнэмшихэд хүргэсэн юм.

1997 оны 4 дүгээр сард Олон Улсын Валютын Сангаас гаргасан “Дэлхий Эдийн Засгийн Байдал Төлөв” илтгэлд улс орнуудын хөгжлийн ангилалыг шинэчилж «тэргүүлэх эдийн засаг»-тай орнуудын тоонд Азийн шинээр аж үйлдвэржсэн 5 орон Сингапур, Өмнөд Солонгос, Тайвань, Хонг Конг болон Израилийг оруулжээ. Аж үйлдвэржсэн хөгжингүй 7 орноос гадна «*тэргүүлэх эдийн засаг*»-тай 16 орон нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) гишүүн Нидерланд, Бельги, Австри, Швейцарь, Ирланд, Исланд, Грек, Финлянд, Норвеги, Дани, Испани, Португал, Люксембург, Австрали, Шинэ Зеланд, Швед билээ. БНСУ 1996 онд OECD-д элссэн юм.

1960-70-аад онд Японы хөгжлийн стратеги нь «*хөөж гүйцэх*», 1980-аад он гэхэд «*гүйцэж түрүүлэх*» эдийн засгийн философи байсан бөгөөд энэ нь ч ёсоор болсон билээ. Энэ стратеги ч Азийн шинээр аж үйлдвэржсэн орнуудын тухайлбал Өмнөд Солонгосын хөгжлийн баримтлал болсон байна. Эрчимтэй хөгжлийн 1980-аад онд хөгжингүй болон тэргүүлэх эдийн засагтай орнуудын эдийн засгийн дундаж өсөлт дөнгөж 1,5-аас 2,5 хувь байхад Азийн “бар” орнуудын хувьд 9-10 хувь байсан нь «*хөөж гүйцэх*» стратеги шинэ зууны эхний 20 жилд биелэх найдвар төрүүлж байсан юм. Солонгосын худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг (KOTRA), Германы эдийн

засгийн өдөр тутмын нэр хүндтэй сонин «*Handelsblatt*» (Торговый листок)-ын гаргасан илтгэлд Шинэ мянганы XXI зууны төгсгөлд хоёр Солонгос нэгдсэн тохиолдолд Зүүн хойд Азийн геополитикийн орчин, хүчний тэнцвэрт ноцтой өөрчлөлт орно гэж үзжээ.

Өмнөд Солонгос ч Хойд Солонгосын хамгийн ойрын холбоотон коммунист орнуудтай дипломат харилцаа тогтоож, олон улсын харилцаанд өөрийн улс төрийн байр сууриа бэхжүүлэх, Хойд Солонгосыг нээлттэй болгох, үндэсний нэгдлийг хэрэгжүүлэх, НҮБ-д гишүүнээр элсэх, улам бүр өсөн нэмэгдэж буй эдийн засагт хэрэгцээтэй түүхий эд, худалдааны хийгээд санхүү, хөрөнгө оруулалтын шинэ зах зээл нээхийн тулд “умардын бодлого” явуулж эхэлсэн юм.

1988 оны Сөүлийн зуны ХХIY Олимп Өмнөд Солонгосын эдийн засгийн хөгжлийн гайхамшигийг “Хан мөрний гайхамшиг”, “Korea” хамтлагийн «*Hand in hand*» (гар гараасаа барилцья) олимпын дуугаар дэлхий дахинд харуулж чадсан билээ.

1990-ээд оны дунд гэхэд л Өмнөд Солонгос болд, ган хайлуулах үйлдвэрлэл, автомат удирдлагатай зарим суурь машин, нэхмэлийн үйлдвэрлэлээр Японы урьд нэгэнтээ гарч автомашин, хөлөг онгоцны үйлдвэрлэлээр хоёроос гуравт орох болов. Мэдээж Солонгост шийдвэрлэх олон чухал асуудал буй нь тодорхой байв. Юуны өмнө урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгон аюулгүйн бат найдвартай тогтолцоог буй болгож, хоёр Солонгосын хооронд дээд түвшинд болон АНУ-тай яриа хэлэлцээг шинээр эхлүүлэх нь чухал билээ. Хамгийн гол ажил холбогдох улсуудын хооронд итгэлцлийг бэхжүүлэх явдал болно.

ХЯМРАЛЫН ЭХЛЭЛ БА ЖИЛ ОРСОН НЬ

Монголчууд *морин жилийг* ихэд билэгшээхийн дээр өөрсдийгөө *бөрт чоноос* гаралтай гэж үздэг. Харин Солонгосчууд өөрсдийгөө *бараас* гаралтай гэж үзэх ажээ. Тиймээс ч Сөүлийн олимпын бэлэг тэмдэгийг бараар дүрсэлсэн нь учиртай. МЭӨ 4333 жилийн өмнө бурхан тэнгэр *бар, баавгай* хоёрыг газар дэлхийд илгээжээ. Тэнгэрийн эзэн сайхь хоёрыг явахын өмнө хэлсэн нэгэн захиас нь дэлхийд

газардаад 100 хоног хар ус, хагд өвс ч амсахгүй байхыг учирлан захижээ. Гэвч баавгай захиасыг эс тэвчиж, харин бар тэнгэрийн эзний зарлигыг ёсоор болгосонд тэрбээр үзэсгэлэнт хунт тайж болон хувирч Пэгтү уулын урьд хормойд үзэсгэлэнт хацар гоо гүнжтэй учирч тэд айл болон амьдарч солонгос үндэстэн үүссэн хэмээх нэгэн домог байх ажээ.

1998 оны 2 дугаар сарын 25-нд Үндэсний Ассамблейн ордны өмнө сөрөг хүчнээс анх удаа Ерөнхийлөгчид сонгогдсон Ким Дэ-жүнгийн тангараг өргөх ёслолд зориулсан багт наадмын үеэр хүч тамир нь сульдсан асар том бар хэвтрээсээ өндийж архиран босч байгаа үзүүлбэр онцгой сэтгэгдэл төрүүлж билээ. Сүүлийн 30 гаруй жилийн түүхэнд Зүүн Азийн эдийн засгийн хөгжлийн гайхамшигийг буй болгож «Азийн бар» болсон энэ орон 1997 оны сүүлчээс эдийн засгийн гүн хямралд орсон ч 1998 оны Бар жилд дахин шинээр мэндэлж байгааг илтгэсэн хэрэг байв. Үнэхээр ч Солонгосчуудын хувьд жил нь орсон билээ.

Өмнөд Солонгосын санхүү эдийн засгийн хямралын шалтгааныг тодруулахад бүс нутгийн валют, санхүүгийн хямралын эх сурвалжаас эхлэн тайлбарлахаас өөр аргагүй юм. Дэлхийн эдийн засагт 1997 оны 7 дугаар сард тохиолдсон үйл явдлын нэг нь Зүүн өмнөд Азийн орнуудын санхүү, эдийн засгийн хямрал байв. Энэхүү хямрал 1997 оны 7 дугаар сард Тайландад эхэлж улмаар Зүүн өмнөд Азийн хэд хэдэн оронд шууд нөлөөлөв (Индонез, Малайз, Филиппин, Сингапур, Өмнөд Солонгос). Учир нь Тайландын Засгийн газрын шийдвэрээр 1997 оны 7 дугаар сарын 2-нд тогтмол ханшны системээс хөвөгч ханшийн системд шилжсэнээр бахтын ханш 7 дугаар сарын 4-нд 80 гаруй хувиар огцом унаж 1 ам. доллар 25 орчим бахт (thailand currency baht) байснаа 45 бахт болж огцом өсөв. Төв банк нь ханш огцом суларч байгаа үед валютын захаа арилжааны шинжтэй халдлагаас хамгаалах зорилгоор интервенц хийснээр хэдхэн сарын дотор нөөцөө шавхжээ. Учир нь тогтмол ханшийн дэглэм барьж байх үед Тайландын олон компани пүүсүүд ам.доллараар зээл авсан байжээ. Ам.доллараар зээл авах нь бахтаар зээл авахаас хавьгүй бага хүүтэй байсан байна. Энэ нь бүс нутгийн хямралын эхлэл болов. Мөнгөний ханш унасны улмаас тус улсын хувийн хэвшлийн зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөр

ихээхэн өсч эдийн засагт дарамт үзүүлжээ. Энэ нь үнэт цаасны зах зээл дээр үнийн хөөрөгдөл гарахад нөлөөлж ханш унаснаас гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгөө татаж эхлэв. Улмаар уг үйл явц үнэт цаасны тэртээ тэргүй унаж байсан ханшийг улам унагасан байна. Ийнхүү Тайланд дахь хямрал бүс нутгийн үнэт цаасны арилжаа, ханшид нөлөөлж 1997 оны 9 дүгээр сараас Малайзийн ринггит, Индонезийн рупий, Филиппины песо, Сингапурын доллар, Өмнөд Солонгосын воны ханш огцом унахад нөлөөлж, хямрал бүс нутгийн шинж чанартай болохыг харуулав. Хямралын нөлөө тухайн үед дөнгөж хямралаас гараад байсан Орос, Латин Америкийн орнууд руу хальж, дахин хүнд цохилт өгсөн билээ.

Гол шалтгаан нь эдийн засгийн хэт өсөлт буюу халалт, макроэдийн засгийн болон валютын арилжааны бодлогын алдаа, санхүүгийн секторын зохион байгуулалт, бүтэц сул, эдийн засагт төрийн оролцоо их байсан, мөн дэлхийн зах зээлийн нөлөө, дотоодын их хэмжээний авилга, хээл хахууль зэргийг дурьдахад хангалттай. Өмнөд Солонгосын хувьд ханш уналт импортоор түүхий эдийн эх сурвалжаа бүрдүүлдэг үйлдвэрүүдийн хувьд хүндхэн цохилт болж энэ нь ажилгүйчүүдийн тоог өсгөхөд нэмэр болов. Гадаадын хөрөнгө оруулалт, дунд болон богино хугацааны түүнчлэн арилжааны зээлийн дийлэнх хувь том үйлдвэр, худалдааны бүлгийнхний гарт очдог байсан нь жижиг, дунд үйлдвэрүүдийг үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх, техник, технологийн шинэчлэл хийхэд улмаар ажлын нэмэгдэл байр шинээр бий болгох боломжийг хумьсан юм. Томоохон бизнес группүүд асар их хэмжээний зээлийг үр ашиг багатай нүсэр салбаруудад зарцуулсан нь өнгөц харахад эдийн засгийн өндөр өсөлтийг харуулсан боловч энэ нь барааны хэт илүүдлийг бий болгож экспорт буурахад хүргэж төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал өсөхөд нөлөөлжээ. Солонгосын эдийн засгийн өндөр өсөлтөд капиталын гадаад миграц буюу гадаадын хөрөнгийн урсгал ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Энэхүү хөрөнгийн өчүүхэн хэсэг нь шууд хөрөнгө оруулалт буюу урт хугацааны хөрөнгө оруулалт эзэлж бусад нь богино хугацаат хөрөнгө оруулалт байжээ. Богино хугацаат хөрөнгө оруулалт ДНБ-ний 7 орчим хувийг эзэлж байсан бол шууд хөрөнгө оруулалт дөнгөж 1 хувь байжээ. Иймээс богино хугацаат хөрөнгө оруулалтын өрөө дарахад нь

байнга хүндрэл гарч улмаар санхүүгийн секторт итгэх итгэл хөрөнгө оруулагчдад буурсан байна. Тиймээс «Hanbu», «Jinro», «Sammi», «Kia» болон бусад долоон томоохон бизнесийн групп, 10 арилжааны банк, даатгал, брокерын пүүсүүд дампуурлын ирмэгт ирж, зарим нь бүр дампуурсан байна. 1998 оны 3 дугаар сарын 1-ний байдлаар 3000 шахам ЖДҮ дампуурсан байна. «Samsung», «LG», «Ssankyong», «Hyundai», «Daewoo» группээс бусад томоохон компаниудын гүйцэтгэл зээлийн хүүгээс доогуур буюу 12 хувиас доош хэмжээнд оржээ. Хөрөнгө оруулалтын ашгийн үзүүлэлт аливаа пүүс компанийн ашигт ажлаар тодорхойлогддог менежмент хамгийн гол үзүүлэлт юм. Хөрөнгө оруулалтын ашгийн үзүүлэлт зээлийн хүүгээс доогуур байвал бизнес явуулсанаас бонд гаргах нь илүү үр дүнтэй гэж олон улсын эдийн засагчид үздэг.

Төсвийн тэнцлийн ашиг, алдагдлын харьцааг дутуу үнэлснээс макроэдийн засгийн бодлого алдагдахад хүрсэн, эдийн засгийн өндөр өсөлтөдөө хэт тайвшран төсөв, мөнгөний хатуу бодлого явуулаагүйгээс хямрал гарах нэг нөхцөл бүрджээ. Өмнөд Солонгосын санхүүгийн сектор засаг төр болон цөөн тооны томоохон компанийн оролцоонд суурилсан, үйл ажиллагаа нь нийтэд ил тод биш, хээл хахуульд гүн автагдсан нь бас нэг том учир шалтгаан байв.

Гадаад нөлөөллийн хувьд 1997 оны эхээр АНУ Холбооны нөөц, дотоод зах зээлээ өргөжүүлэхийн тулд богино хугацаат зээлийн хүүг өсгөжээ. Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтаас орох ашиг аж үйлдвэржсэн болон хөгжингүй орнуудад өссөн нь капиталын урсгал хөгжиж буй зах зээлээс аж үйлдвэржсэн орнуудын зах зээлд шилжих хандлагатай болсон байв. Өмнөд Солонгос нь импортын хувьд Японоос багагүй хамааралтай байдаг нь Японы үндэсний валют иений ханш 1997 оны дундаас мэдэгдэхүйц доошилсон нь барааны өрсөлдөх чадварт нөлөөлж цэвэр экспортын өсөлтөнд эсрэг нөлөөлсөн төдийгүй тэнцлийн урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлсэн байна.

Хэдийгээр Өмнөд Солонгос санхүү, эдийн засгийн гүн хямралд орсон боловч Зүүн Өмнөд Азийн бусад орныг бодвол хямралаас хамгийн богино хугацаанд үр дүнтэй гарч байгаа орон гэж олон улсын санхүүгийн мэргэжилтнүүд нэгэнтээ тэмдэглэсэн юм. Өмнөд Солонгосын Засгийн газар ОУВС-гийн авралын 57 тэрбум ам.долларын

зээлийг банк, санхүүгийн тогтолцоог шинэчлэх, ЖДҮ-үүдийг дэмжих, макроэдийн засгийг тогтворжуулах, ханш уналтыг барих зэрэг олон чухал арга хэмжээнд зарцуулж эхлэв. Шинэ Засгийн газар улс орон даяар алт цуглуулах хөдөлгөөн өрнүүлж 24 тонн алтыг нэгэнт Сингапур дахь Олон улсын банканд борлуулсан байна. 1998 оны 2 дугаар сарын сүүлчээр Өмнөд Солонгосын гадаад өр 150,3 тэрбум доллар байсан нь өмнөх сарынхтай харьцуулахад 900 саяар буурчээ. 2 дугаар сард тус улсын удаан хугацааны гадаад өрийн хэмжээ ОУВС-гийн тусламжийн зээлийг оролцуулаад 1,7 тэрбумаар өссөн байхад хувийн хэвшлийн богино хугацааны өр 2,6 тэрбум доллараар буурсан байна. Хямрал эхлэхийн өмнө Өмнөд Солонгосын гадаад валютын нөөц 9 тэрбум доллар байсан бол нөөцийн хэмжээ он гарахад 24 тэрбумаар өсчээ.

Статистикийн бүртгэлд ордоггүй, татварт хамрагддаггүй урсгалаар их хэмжээний гадаад валют гадагшилж байгаа шалтгаан нь хууль бусаар ажиллаж байгаа гадаадынхан гэж үзэж тэднийг нутагт нь буцаах бодлого барих болов. Мөн эдийн засагт төрөөс хэт оролцож байгааг зогсоох бодлого баримталж үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулж засаглалын тогтолцоог өөрчилж ерөнхийлөгчийн засаглалаас кабинетын тогтолцоонд шилжих бэлтгэл ажил яригдаж эхэлж, 2000 оноос хэрэгжүүлэх тухай асуудал ч яригдах болсон юм.

1998 оны намар Канадын Ванкувэр хотноо болсон АПЕК-ийн 9 дэх удаагийн дээд уулзалт дээр АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтон хэлэхдээ эдийн засгийн хүчин чадлаар дэлхийд 11-т ордог, дайны дараах “эдийн засгийн зэрэглэлэнд” «таван барын» нэг болж байсан Өмнөд Солонгос хямралаас богино хугацаанд гарч чадах орон мөн гэж онцлон тэмдэглэсэн юм. «Бид Өмнөд Солонгосын Засгийн газрын зарласан шинэтгэлийн хөтөлбөрийг бүрэн дүүрэн сайшаан дэмжиж байна» гэж Дэлхийн банкны Ерөнхийлөгч Жеймс Вольфенсон 10 тэрбум ам.долларын зээл олгохын өмнө мэдэгдсэн билээ. Ардчилалыг хөгжүүлж, эдийн засгийн үсрэлт хийж, түүнчлэн Зүүн Азийн санхүүгийн хямралыг богино хугацаанд амжилттай даван туулсан Өмнөд Солонгост 1999 оны 4 дүгээр сард Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Цог Жавхланта хатан хаан II Елизабет анх удаагаа төрийн айлчлал хийв. Үнэхээр Өмнөд Солонгос XXI зуунд тогтвортой хөгжлийнхөө замд орох чадавхтай орон гэдгээ харуулж

чадсан билээ.

Хямралын шалтгааныг 20 жилийн дараагаар дахин эргэцүүлэхэд Тайландын төв банк ханшийг удирдахыг оролдсон ч, үүнийг хийх хангалттай хэмжээний гадаад валютын нөөцгүй байсан явдал юм. Харамсалтай нь бусад төв банкууд ч үүнтэй адил алдаа гаргажээ. Олон төв банкууд тухайн үед ханшийг удирдах нь асуудалгүй бөгөөд ханшийг сулруулахгүй байж болно хэмээн мэдэгдэж байсан. Нөгөөтэйгүүр ам.долларын зээлийн хүүгийн түвшин үндэсний валютын зээлийн хүүгээс хавьгүй доогуур байснаас компаниуд болон хувь хүмүүс дотоодын валютаа ам.долларын эсрэг тогтвортой байна гэж үзэж ам.доллараар зээл авч эхэлсэн байна. Эцэст нь төв банк үндэсний валютаа тогтвортой байлгаж чадалгүй ханш огцом суларснаар, олон компаниуд дампуурч, ажилгүйдэл буй болжээ.

ОУВС, Дэлхийн банк болон бусад олон улсын байгууллагууд энэхүү хямралтай тэмцэхэд зохих алдаа гаргасан байна. Тэд эдийн засгийн үйл ажиллагааг дэмжихийн тулд өр төлөхөд зориулж шаардлагатай санхүүжилт хийхийн оронд Засгийн газарт хатуу хэмжүүр тогтоож, төсвийн зардлыг танах шаардлага тавьж, тэдгээр орнуудын банкуудыг сүйрүүлэх алхам хийжээ. Ингэснээр хямрал илүү гүнзгийрч, асуудлууд хүндэрчээ.

Эсрэгээрээ, үүнээс 10 жилийн дараа бий болсон ипотекийн зээлийн хямралын үеэр АНУ-ын Холбооны нөөцийн банк дээрхээс эрс ялгаатай бодлого хэрэгжүүлж санхүүгийн байгууллагуудаа аварч үлдсэн түүхтэй юм.

Шинжээчид Азийн санхүүгийн хямралаас авах гол сургамж бол төв банк болон Засгийн газар зах зээлийн үйл хөдлөлд хэт оролцох, гадаад валютын ханшийг удирдах гэж оролдохгүй байх нь зүйтэй гэж үзжээ. Мөн Засгийн газар болон хувь хүмүүс эрсдэлийг бүрэн тооцолгүйгээр өөрийн орлогын гол эх үүсвэрээс ялгаатай валютаар өр үүсгэх нь буруу гэжээ.⁶

2000 оны 5 дугаар сард Тайландын Чиан Май хотод Азийн хөгжлийн банкны Захиралуудын зөвлөлийн 33 дахь удаагийн

уулзалтад АСЕАН+3-ийн Сангийн сайд нар оролцож, чуулганы үеэр төлөөлөгчид Азийн санхүүгийн хямралын гол сургамж дүгнэлт нь Азийн нэгдсэн валютын тогтолцоог буй болгох, Азийн валютын санг байгуулах явдал гэсэн саналыг дэвшүүлсэн явдал юм. Үүнийг Чиан Май-н санаачилга гэх бөгөөд 2008 оноос эхэлсэн дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал дээрхийг дахин зөв болохыг нотолсон ажгуу.

Өмнөд Солонгос нь ДНБ-ний үйлдвэрлэлээр дэлхийн эдийн засагт 13 дугаарт орж, 20-ийн бүлгийн гишүүн болсон бөгөөд Бразил, Мексикийн эдийн засагтай харьцуулахад илүү чухал зүйл нь урт хугацаанд тогтвортой өндөр өсөлтийн хурдтай байгаа нь BRIC-ийн хураангуй нэрийг өөрчлөхөд хүргэнэ гэж санхүүгийн групп *Goldman sachs* үзсэн байна. *Bloomberg*-ын шинжээч Уильям Песекийн үзэж байснаар Өмнөд Солонгос амжилттай хөгжиж байгаа N-11-ийн эдийн засгаас гарч өөр нэг BRIC-ийг буй болгож байна гэжээ.

2015 оны хөгжлийн шинэчилсэн стратегиар Өмнөд Солонгосын эдийн засгийн өсөлт жилд дундажаар 5 хувь байж, 2025 он гэхэд Канадыг, 2035 онд Италийг, 2045 он гэхэд Японыг ардаа орхих ажээ. 2050 оны өмнө хоёр Солонгос нэгдсэн тохиолдолд Их Британи, Францын урд нэгэнт гарч Их долоогийн бүлэгт багтах болно хэмээн үзэж байна. *Goldman sachs*-ын үзэж байгаагаар 2050 он гэхэд Өмнөд Солонгос ДНБ-ийн үйлдвэрлэлээр дэлхийд 13-т, ДНБ-ийн нэг хүнд оногдох хэмжээгээр 90,2 мянган ам долларт хүрч, дэлхийд эхний 10 дугаарт орно гэж үзэж буй нь тус орны эдийн засгийн хөгжлийн чадавхийг илэрхийлсэн хэрэг юм.

Өнөөдөр Өмнөд Солонгос нь НҮБ-ын бүрэн эрхт гишүүнээс гадна, дэлхийн хамгийн баян орнуудыг нэгтгэдэг OECD, түүнчлэн G-20, АРЕС, АСЕМ, АСЕАН+3, АРФ, ФЕАЛАК -ын гишүүн юм.

Дэлхийн банк, ОУВС-гийн тэргүүлэх эдийн засагтай орнуудын өндөр орлоготой улсуудын ангиллаар Сөүл хот дэлхийн санхүү, худалдааны TOP-10 хотын нэг, хамгийн баян бүс нутгаар Ульсан дүүрэг орж байгаа бөгөөд 2015 онд энэ дүүрэг ДНБ-ний худалдан авах чадавхийн (PPP) нэг хүнд оногдох үнэлгээ 60 мянга 665 ам. доллар болж байжээ. Өмнөд Солонгос нь дэлхийн TOP-10 экспортлогчийн нэг бөгөөд АНУ-ын худалдааны 6 дахь түнш, тэрчлэн Чөлөөт худалдааны

⁶ Mark Mobius. Looking back at the lessons of the Asian Financial Crisis on its 20th anniversary. Jul. 6, 2017 Business Insider

хэлэлцээр байгуулж, Европын Холбооны 8 дахь түнш болов. Түүнчлэн дэлхийн хамгийн том хөлөг онгоц үйлдвэрлэгч, дэлхийн TOP-5 автомашин үйлдвэрлэгчийн нэг, Азийн хамгийн том газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч, гол эдийн засгийн салбар хоорондын инновацичлал, мэдээллийн технологийн хөгжлөөр дэлхийд тэргүүлэгч орон болсон байна.

ШИНЭ УМАРДЫН БОДЛОГО

Солонгосын хойгийн хурцадмал байдлыг эерэг тийш хандуулах чиглэлд АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампын явуулж буй хүчтэй шахалт, НҮБ-ын АЗ-ийн хориг, Хойд Солонгосын удирдагч Ким Жон-уны шинэ жилээр хийсэн зоримог мэдэгдэл, нөгөө нь Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Мүн Жэ-инийн Шинэ Умардын бодлого, Пёнчаны өвлийн олимпын XXIII тоглолт чухал нөлөө үзүүлсэн гэдэг нь тодорхой билээ.

БНСУ 2011 оны 7 дугаар сард ӨАБНУ-ын Дурбан хотноо хуралдсан ОУОХ-ны 123 чуулганаар Өвлийн XXIII олимпыг 2018 онд Пёнчан хотноо зохион байгуулах эрхийг Германы Мюнхен, Францын Аннеси хотуудтай өрсөлдөн авчээ. Энэ нь 1988 оны Сөүлийн зуны олимпоос хойш 30 жилийн дараа, 1998 оны Японы Наганогийн өвлийн олимпоос хойш 20 жилийн дараа, Азид 2 дахь удаагаа зохион байгуулагдаж буй өвлийн олимп болов. Тийнхүү Пёнчан 2018 өвлийн XXIII олимп ОУОХ-ны гишүүн 92 орон, тусгай бүсийн 2950 гаруй тамирчид 15 спортын 102 төрлөөр 102 багц медалийн төлөө өрсөлдөж, Өмнөд Солонгос өөрийн хөгжлийн гайхамшгийг дэлхий дахинд дахин нотлон харуулав. Пёнчаны өвлийн олимпын нээлтэд БНАСАУ-ын Ардын дээд хурлын Тэргүүлэгчдийн дарга Ким Ён-нам, Хойд Солонгосын удирдагчийн дүү охин, СХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн Ким Ён-жон нар оролцож, хоёр Солонгосын баг хамтран оролцсон нь бэлэг дэмбэрэлтэй үйл явдал болов. Энэ нь хурцадмал байдлыг өөрчлөхөд чухал хүчин зүйл болсныг тэмдэглэх ёстой.

Мүн Жэ-ин 2017 оны 5 дугаар сарын 9-нд БНСУ-ын 12 дахь ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа түүний зарласан гадаад бодлогыг Британийн сэтгүүлч Майкл Брин (Michael Breen) “Wall Street” сэтгүүлд

түүний овгийн нэртэй уялдуулан “Moonshine Era” буюу “сар бүтэн хиртэж” эхэлсэн тухай бичсэн байдаг.⁷ Ким Дэ-жүнь Ерөнхийлөгчийн үед “Sunshine policy” буюу “Нарны илч” бодлогыг хэрэгжүүлж байсан, эдүгээ “сарны туяа” бодлогыг хэрэгжүүлж эхэллээ гэж тэмдэглэж байв. Тэрбээр сонгогдсон даруйд АНУ, БНХАУ, Япон, ОХУ-д тусгай элч илгээж, утга нь Пёнъяны цөмийн болон пуужингийн хөтөлбөрийг зогсоох, солонгос хоорондын яриа хэлэлцээг эхлүүлэх, Хойд Солонгост шахалт үзүүлэх тухай байв.

БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ-ин Дорны Эдийн засгийн форумын 3 дахь удаагийн чуулганд оролцох үеэрээ 2017 оны 9 дүгээр сарын 7-нд Владивосток дахь Алс Дорнодын Холбооны их сургууль дээр үг хэлэхдээ: “Шинэ Умардын Бодлого”-ыг албан ёсоор зарласан юм.⁸ 1988 оны Сөүлийн Олимпын өмнө БНСУ-ын Ерөнхийлөгч Но Тэ-үү Хойд Солонгосын хамгийн ойр холбоотон коммунист орнуудтай дипломат харилцаа тогтоож, худалдаа, хөрөнгө оруулалт болон түүхий эдийн шинэ зах зээл нээх, НҮБ-д элсэх зэрэг зорилготой “Умардын бодлого”-ыг анх дэвшүүлж амжилттай хэрэгжүүлсэн юм.⁹

Анх Ерөнхийлөгч Мүн Жэ-инийн Шинэ Умардын бодлогын үзэл санаа анх ХБНГУ-ын Хамбург хотноо зохиогдсон Их 20-ийн дээд уулзалтад оролцохын өмнө 2017 оны 7 дугаар сард Берлинд албан ёсны айлчлал хийх үеэрээ хэлсэн үгэнд тусгалаа олж, энхтайван, хамтын ажиллагааны суурин дээр Хойд Солонгосын цөмийн болон пуужингийн заналхийллийг шийдвэрлэж, Солонгосын хойгт “Шинэ эдийн засгийн замын зураг” гаргах тухай байв.¹⁰

Тэрбээр Владивостокт хэлсэн үгэндээ ЕврАзийн уудам орон зай тухайлбал, ОХУ-ын Алс дорнодын бүс, Зүүн хойд Хятад, Монгол, Төв Азийн орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг хүчирхэгжүүлэх явдал юм. Өрнөдийн эдийн засгийн хоригт орсон ОХУ-тай есөн гүүр тухайлбал, байгалийн хий, төмөр зам, далайн боомт, эрчим хүч, Хойд мөсөн далайн хөлөг онгоцны зам, хөлөг онгоцны үйлдвэрлэл,

⁷ The New President's Governance style can best be described as “Subtle Moonshine”. Korea JoongAng Daily. May 17, 2017

⁸ Moon Jae-in Government's New Northern Policy. KBS World. Sept. 18, 2017

⁹ Kim Hak-joon. Korea's Relations with her Neighbors in a Changing World. Seoul.: 1995, pp. 25-30

¹⁰ Noh Ji-won. The Administration is looking to create a “New Economic Road Map for the Korean Peninsula”. http://english.hani.co.kr/arti/english_edition/e_national/

хөдөлмөр эрхлэлт, ХАА, загас агнуурын чиглэлд хамтын ажиллагааны гүүрийг хэрхэн, яаж цогцлоон байгуулах тухай ажээ.¹¹ Тийнхүү Ерөнхийлөгчийн дэргэд Умардын эдийн засгийн хамтын ажиллагааны хороо (Song Young-gil, the chief of Presidential Committee on Northern Economic Cooperation) байгуулагдан идэвхтэй ажиллаж байгаа ажээ.

2018 оны 5 дугаар сарын 3-нд Сөүлд зохиогдсон Кореа форумд Нэгдлийн сайд Чой Мён-гён хэлэхдээ: Солонгос хооронд эдийн засгийн 30 гаруй мега төсөл, түүний дотор Donghae and Gyeongui train lines-ийг шинэчлэх тухай мэдэгдсэн байна.¹²

Панмунжом дахь Солонгосын хоорондын гуравдахь удаагийн дээд уулзалтын үеэр БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ-ин Хойд Солонгосын удирдагч Ким Жон-унд “New Economic Road Map in Korean Peninsula” хэмээх м USB drive e-book-ийг гардуулсан байна.¹³

Уг blueprint-эд Солонгосын хойгийг эдийн засгийн гурван бүсэд хувааж хөгжүүлэхээр тусгажээ. Тухайлбал Солонгосын хойгийн баруун эргийг Хятадтай холбож, ложистикийн төв болгон хөгжүүлэх, зүүн эргийг Оростой холбосон эрчим хүчний сүлжээ бий болгох, цаашлаад Европтой холбогдох, одоогийн хоёр Солонгосын хилийн бүсийг аялал жуулчлалын төв болгохоор тусгасан ажээ. Энэ бол Шинэ Умардын бодлогын эдийн засгийн бодлогын цөм нь юм.

Гэхдээ АНУ, БНАСАУ-ын харилцааны цаашдын чиг хандлага Шинэ Умардын бодлогын амжилттай хэрэгжилтэд шууд нөлөөлнө.

Шинэ Өмнөдийн бодлого нь АНУ, БНХАУ-тай эдийн засгийн дипломат ажиллагааны хүрээнд ирээдүйд чиглэлсэн өргөтгөсөн түншлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай юм.¹⁴ Тэрбээр “Шинэ Өмнөдийн бодлого”-ын хүрээнд АСЕАН-тай эдийн засгийн талаар нягт интеграцчлагдах тухай байв.¹⁵

11 Moon Jae-in Government's New Northern Policy...

12 Jung Min-ho. Denuclearization is prerequisite for interKorean economic cooperation. May 3, 2018

13 Kim Jong Un received a USB drive from South Korea's president with a blueprint for connecting North Korea with the world. The Korea Times. May 6, 2018

14 Noh Ji-won. The Administration is looking to create a “New Economic Road Map for the Korean Peninsula”.

15 By Noh Ji-won. South Koreans have positive view of President Moon's new Northern and new Southern policies. Dec. 17, 2017

СОЛОНГОСЫН САНСРЫН ХӨТӨЛБӨР

2006 оны 4 дугаар сарын 8-нд Солонгосын анхны, мөн анхны эмэгтэй сансрын нисгэгч доктор Ий Су-ён (Yi So-Yeon) 31 насандаа ОХУ-ын Союз ТМА-12 сансрын хөлгөөр Оросын хоёр сансрын нисэгчийн хамт хөөрч, сансарт 18 төрлийн эрдэм шинжилгээ-туршилтын ажил гүйцэтгээд 4 дүгээр сарын 19-нд Олон улсын сансрын станцын гишүүн АНУ-ын иргэн Пегги Уиньстон (Peggy Whinston), ОХУ-ын иргэн Юрий Маленченко нарын хамт эх дэлхийдээ эсэн мэнд газарджээ. Тэрбээр анхны сансрын жуулчин эмэгтэй болсон юм. Өмнөд Солонгосын албаныхан мэдээлснээр түүний сургалт ба нислэгийн төлөө 26 тэрбум вон буюу 20 сая ам. доллар төлсөн байна.

Ий Су-ён Кваньжү дэх Шинжлэх ухааны дунд сургууль, баклавар, магистрын зэргийг Тэжонь дахь Солонгосын Шинжлэх ухаан, технологийн их сургуульд механикийн чиглэлээр хамгаалж, 2008 оны 2 дугаар сард мөнхүү сургуульд био-технологийн чиглэлээр докторын зэрэг хамгаалжээ.

Өнөөдөр Солонгосын Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх (Advanced) институтын магистр Пак Жи-ён, Ханянь Их сургуулийн судлаач Юнь Сок-ох, Солонгосын агаарын хүчний туршин нисгэгч Ий Жинь-ён, Пучонь дахь Намбу Цагдаагийн газрын дэслэгч Жань Жунь-сонь, Мажик мэдээллийн технологийн компанийн технологийн удирдагч Рю Жён-вон, Самсунг хөгжлийн хүрээлэнгийн судлаач Ий Ханн-гюү, Сөүлийн Үндэсний Их сургуулийн технологийн сургуулийн магистр Цой Ах-жеонь, Солонгосын суурь шинжлэх ухааны институтын судлаач Ким Ёнь-минь нар сансрын нислэгийн хөтөлбөрт хамрагдан ажиллаж байгаа ажээ.

Сүүлийн жилүүдэд БНСУ нь сансар судлалын чиглэлд онцгой анхаарч байгаа бөгөөд 2008 онд Наро Сансрын Төв ашиглалтанд орсноор тус улс сансрын хөөрөх буудалтай дэлхийн 13 дахь улс болов. 2009 оны 8 дугаар сарын 25-нд БНСУ, ОХУ-ын хамтарсан Наро-1 ачаа тээврийн сансрын хөлгийг амжилттай хөөргөсөн байна. Ер нь Солонгос нь сансрын хөтөлбөрийн салбарт ОХУ-тай идэвхтэй хамтран ажиллаж байгаа юм. Бүр 1999 онд Тэжонь дахь Сансрын судалгааны институтын (KARI) лабораторид бүтээсэн “Арирань-1”

хиймэл дагуулыг амжилттай хөөргөж байсан юм. 2006 оны 4 дүгээр сард “Арирань-2” хиймэл дагуулыг хөөргөжээ. Одоогоор 9 хиймэл дагуул хөөргөөд байгаа ажээ. KARI нь Солонгосын Сансар судлалын агентлаг бөгөөд 1981 онд байгуулагдсан байна.

Солонгосын сарыг танадан судлах хөтөлбөр: Өмнөд Солонгос саран дээр газардагч бүтээж байна. Өмнөд Солонгосын Шинжлэх ухааны яамнаас саран дээр газардагч явуулах хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлжээ. Тус улс сарны гадарга болон бусад маш нарийн судалгаануудыг хийхээр уг төсөлдөө тусгажээ. Одоо технологийн баазаа боловсруулж байгаа бөгөөд 2020 он гэхэд уг төсөл бүрэн хэрэгжиж эхлэх ажээ.

DIGITAL KOREA

Эдүгээ мэдлэг болон технологит суурилсан эдийн засгийн онол-аргазүй, шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, олон талт судалгаанд суурилсан дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай болж байна. Хүн төрөлхтөн шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай тухай дээр тэмдэглэсэн. Мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь бүтэц, дэд байгууламж, нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграчлал, инновацичлал улс орны хөгжлийн гол хэмжүүр болов.

Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, эдийн засгийн шинжлэх ухааны хуучин тодорхойлолтууд шинчлэгдэж, энэ нь эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, цаг хугацааны алдагдалыг үлэмж бууруулах болов. Нэг талаас дэлхий дахины худалдаа-эдийн засаг, зах зээлийн харилцаанд мөнгө, санхүү, хөрөнгө, ажиллах хүчний асар өргөн шилжилт хөдөлгөөн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдлэг, мэдээлэлийн хил хязгааргүй урсгал явагдаж, улс орнуудын харилцан хамаарал урьд өмнө байгаагүйгээр гүнзгийрч, түүнд суурилсан даяаршсан макро шинэ ертөнц буй болж, нөгөө талд кибер хэмээх

цоо шинэ орон зай, орчин буй болж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлөөс үүдэн мэдээллийн ертөнцөд томоохон өөрчлөлтүүд гарч, мэдээллийн аюулгүй байдал хэмээх шинэ ойлголт буй болов.

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний нэг том нээлт нь амьдрах геополитикийн орон зайгаа цоо шинээр “тэлсэн” явдал юм. Энэ шинэ орон зайг цахим орон зай буюу *cyber space* гэх бөгөөд хүний оюуны бүтээл болсон тулааны энэ шинэ орон зай хүн төрөлхтний амьдралд онцгой өөрчлөлт гаргаж, цаашид ч олон өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой байна. Хүн төрөлхтөн материаллаг зүйлээс хамаарах нь эрс багасч, бодит биш жишээлбэл, интернет банк, виртуаль эмнэлэг гэх мэт буй болж, цахим мөнгөөр гүйлгээ хийж, цахим дуудлага худалдаанд оролцож, маш өргөн сонголт бүхий шинэ төрлийн “new market”-д ороод байна. Бодит биет бүхий ертөнц цахим ертөнцөд *virtual* хэлбэртэй болж байгаа нь түүний хамгийн түгээмэл шинж юм. Кибер технологийн хурдацтай хөгжлийн үр дагавараар дэлхий нийтийн аюулгүй байдал улам их эрсдэлтэй болж, санамсаргүй байдлаар өчүүхэн зүйлээс ч асар их хор хөнөөл учирч болзошгүй байдал үүсээд буй.

Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багсч байна. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, хил хязгааргүй эдийн засгийн нэгдсэн нэг орон зай болсон байна. Өөр өөр соёл иргэншил, эдийн засаг, эрхзүйн тогтолцоотой 190 гаруй улс гүрэн интернетэд холбогдож, цахим сүлжээ нь бизнес, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, татвар, мэдээлэл, боловсрол, теле холбоо, ажил эрхлэлт, эрүүл мэнд энтертаймент гээд нийгмийн бүхий л харилцааг өөртөө нэгтгэж байна.

АНУ-ын ҮНО (GNI-Gross National Income)-д эзлэх дижитал эдийн засгийн байр суурь тасралтгүй өсөн нэмэгдсээр байна. 2013 онд АНУ-д дижитал эдийн засгийн салбарт 300 тэрбум ам. долларын бүтээгдэхүүн, үйлчилгээг буй болгосон байх бөгөөд ойрын 10 жилд энэ үзүүлэлт 6.1 их наяд ам. доллараар хэмжигдэх ажээ. *McKinsey and*

Со-гийн судалгаагаар АНУ-ын 10 доллар тутмын 1 нь биет мөнгөн хэлбэрт байгаа бөгөөд үлдсэн 9 нь цахим хэлбэртэй байдаг байна. 2016 онд Их 20 бүлгийн эдийн засагт дижитал эдийн засгийн эзлэх байр 4.2 их наяд ам. долларт хүрэх ажээ. 2012 оны байдлаар Их Британийн дижитал эдийн засаг ДНБ-ийн 8.3 хувьтай тэнцэж байжээ.

2013 оноос АНУ 3 хэмжээс технологийг ашигласнаар байгалийн хий, газрын тос, шатдаг занарын олборлолтоор дэлхийд тэргүүн байрт гарч ирэв.

Швед, Сингапур дижитал эдийн засагтай орнуудын хамгийн хүчтэй өрсөлдөгчид гэдгийг Дэлхийн эдийн засгийн форумын судалгаа харуулжээ. Скандинав, Азийн орнууд мэдээлэл, харилцаа холбооны технологийг хамгийн үр ашигтай хэрэглэж буй орнууд гэнэ. Энэ үзүүлэлтээр Финланд *суравдугаарт*, Швейцарь *дөрөвдүгээрт*, харин АНУ *тавдугаарт* эрэмбэлэгдэж байна. Дэлхийн эдийн засгийн форумар мэдээлэл, харилцаа холбооны технологи нь дэлхийн эдийн засаг, байгаль орчин, нийгмийг тогтвортой байлгах гол түлхүүр гэдгийг онцолжээ. Ялангуяа дэлхийн эдийн засаг дахь хориод жилийн ноцтой хямралын дараа мэдээлэл, харилцаа холбооны технологи маш чухал гэдгийг улс орнууд хүлээн зөвшөөрч байна.

Мэдээллийн технологиор дэлхийд тэргүүлж буй Сингапур улсын дараа Азийн бар орнууд Өмнөд Солонгос, Тайвань болон Хонг Конг бичигджээ. Харин Канад шилдэг арвын тоонд багтаж байгаа гэнэ. Дээрх судалгааг дэлхийн 138 оронд явуулсан ажээ. Мөн бизнес, дэд бүтэц, байгаль орчны салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологи хамгийн өргөн нэвтэрсэн нь гэнэ.

XXI зууны эхнээс глобал эдийн засгийн харилцаанд бүтцийн шинэчлэл явагдаж дижитал эдийн засаг гол үүрэг гүйцэтгэж, глобал шинж чанартай, гэхдээ маш хурдан өөрчлөгдөж байна.

Өнөөгийн Өмнөд Солонгос нь шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай орон юм. БНСУ нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн дэд бүтэц, суурь байгууламж, нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох

интеграцлал, инновацичлалаар дэлхийд хамгийн өндөрт орж байна. 2015 оны «*The Economist*» сэтгүүлийн судалгаагаар Өмнөд Солонгос мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадавхиар дэлхийд 3 дугаарт, е-бизнесээр 10 дугаарт, е-засаглалаар 6 дугаарт орж байсан нь хуучирсан тоо болов. 2015 оны «*Financial Times*» сонины судалгаагаар дэлхийд өндөр хурдны интернет хэрэглэгчид 1 тэрбум, е-бизнесээр 350 сая хүн ажил, амьдралаа явуулж буй ажээ. 2015 онд хөгжингүй, тэргүүлэх эдийн засагтай орнуудыг эгнээндээ нэгтгэдэг “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага”-аас 15 настай өсвөр үеийнхний дунд явуулсан компьютерийн мэдлэгийн чансаа тогтоох судалгаагаар Өмнөд Солонгос *нэгдүгээрт*, Шинэ Зеланд *хоёрт*, Австрали *гуравт* оржээ. Гол үзүүлэлт нь компьютертай ажиллах чадвар, интернэтээс хэрэгтэй мэдээллээ хайх чадавхиас гадна цахим шуудан болон олон нийтийн сүлжээ (social network) ашиглах болон хэрэглэх чадвар орсон байна.

Мүн Жэ-ин БНСУ-ын 12 дахь Ерөнхийлөгчөөр сонгогдсны дараа Аж үйлдвэрийн IV хувьсгалын хороог өөрийн дэргэд байгуулав. Samsung electronics мэдээллийн технологийн хөгжлийн дэлхийд хоёрдугаар байранд орж байгаа бөгөөд android үйлдлийн Samsung Galaxy S9 гол брэнд билээ

2017 оны 11 дугаар сард Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Мүн Жэ-иний ивээл дор «*e-Korea: Towards Digitization*» сэдэвт олон улсын томоохон арга хэмжээ анх удаагаа болж өнгөрөв. Энэ үеэр шинээр эмхлэн байгуулагдсан Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа-холбооны технологи, ирээдүй төлөвлөлтийн сайд Юү овогтын (Yu Yeong-min) тэмдэглэсэнээр: “Дэлхий ертөнц дижитал хувьсгалын үр дүнд үйлдвэрлэлийн хөдөлгөгч хүч, хуваарилалт болон кибер ертөнцийн үйл явцыг хувирган өөрчлөөд зогсохгүй хүмүүсийн өдөр тутмын амьдралын чанар, хэв маягийг ч үндсээр нь өөрчилж байна” гэжээ. Гадаад худалдаа, үйлдвэр, эрчим хүчний сайд Пэйк овогт (Paik Ungyu) хэлэхдээ: «Солонгосын эдийн засаг, үйлдвэрлэлийг үндсээр нь өөрчилж буй гол хүчин зүйл, динамик нь *e-revolution* болж байна” гэжээ. Тэрбээр цааш нь хэлэхдээ: “Бидний ирээдүйг чиглэсэн шинэ үйлдэрлэл бол IT (information technology), NT (nano-technology), BT(bio-technology), NPM (new and precision materials буюу метал,

шингэн, хий, хатуу нягт бодисыг шинэ технологийн инновацичлалын туслалцаатайгаар хослуулж цоо шинэ үеийн материал гаргаж авах), ET (environment and new energy technology), Optical sectors (гэрлийн энерги, долгионы хурд, уртын онцлогийг ашигласан технологийг машин, механизм, үйлдвэрийн эд ангиуд, системийн үйлдвэрлэл, лазерийн үйлдвэрлэл, роботчлал, хараазүйн судлал), Aerospace technology юм. Тиймээс ирэх жилүүдэд R&D (Research and Development) чиглэлд үлэмж хөрөнгө оруулалт хийнэ” гэсэн байна. Rockwell International группын тэргүүн бөгөөд CEO солонгос гаралтай америк Davis Dong тэмдэглэн хэлэхдээ: “*e-manufacturing* гэдэг нь мэдээллийн технологид суурилсан e-бизнесийн моделиар жолоодон тухайлбал, үлэмж том цахилгаан станцын үйлдвэрлэлийг ч энэхүү хувьсгалын үр дүнд кибер орчинд буй болгосон цагт, үлэмж том үйлдвэрлэлийн бодит бүтээмжийг дараагийн түвшинд буй болгох болно” гэсэн байна. Энэ бол *new economics* буюу *digital economy* ажээ.

“Korea Telecom”-ын мэдээлснээр өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд тулгуурласан мэдээллийн дэд бүтэц буюу суурь байгууламж цогц бүрдсэн нь Солонгосчуудын амьдралыг чанарыг үндсээр нь өөрчилж байгаа ажээ. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд интеграцлагдсан 45 мянган төрийн институци *e-government*-ийг нэгэнт буй болгож, энэ нь солонгосчуудад хамгийн хурдан шуурхай засаглалын үйлчилгээг санал болгож байна. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд холбогдсон 13 мянга гаруй дунд, их, дээд сургууль өндөр зэрэглэлийн чанартай *e-education* тогтолцоог буй болгожээ. 3.5 сая жижиг, дунд үйлдвэрлэгчид дижиталчлагдсан системд холбогдон e-commerce-г суурилсан *B-to-B*-гийн (*Business-2-Business*) гарцтай болсон байна. Мэдээллийн технологид үндэслэсэн бизнесийн хувьсгал ажлын байрны зах зээлийг эрс өргөжүүлж, нэмэгдсэн өртөг илүү өндөр шингээсэн бизнесийг буй болгов. Өндөр хурдны сүлжээнд суурилсан *on-line* эмнэлгийн үйлчилгээ амьдралын чанарыг эрхгүй өөрчилж буй ажээ. Энэ бүгдийн үр дүнд Шинэ мянганы эрин үеийн эхнээс Солонгос нь *e-Society*-г байгуулж байгаа ажээ.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт зах зээлийн судалгаа хийж, дүн шинжилгээ гарах, мэргэжлийн өндөр зэрэглэлийн зөвөлгөө үзүүлдэг Gartner, IDC зэрэг олон улсын нэр хүндтэй

хамгийн том компаниудын 2015 оны чансааны үнэлгээгээр дэлхийн хөдөлгөөнт холбооны топ 5 компаний *тэргүүнд* Samsung, *хоёрт*. Apple, *гуравт*. Nokia, *дөрөвт*. Хятадын ZTE, *тавд*. Өмнөд Солонгосын LG зэрэг үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүд орсон байна. Дэлхийн хөдөлгөөнт холбооны зах зээл дээр Samsung компаний андронд үйлдлийн системтэй Galaxy S загварын гар утас баттай байр сууриа нэгэнт эзлэв. Samsung групп «хатуу диск уншигч» (DHD) үйлдвэрлэгч АНУ-ын Seagate technology хэмээх дэлхийн хамгийн том компанийн өндөр технологийн үйлдвэрлэл, Rolls-Royce Airbus A380 онгоцны Trent 900 загварын хөдөлгүүр, Boeing 787 Dreamliner-ийн төсөлд гол үүрэг гүйцэтгэж байгаа ажээ. Өмнөд Солонгосын biopharmaceuticals-ын салбарын хөгжил дэлхийд тэргүүлэх байранд гарч ирэв.

Үлдэж буй гол асуудал нь cyber ертөнцөд мэдээллийн технологийн аюулгүй байдлыг найдвартай хангах тухай байв. Тиймээс 2002 онд «Кибер орон зайг террорист халдлагаас хамгаалах тухай хууль»-ийг хууль тогтоох дээд байгууллага Үндэсний Ассамблейгаас батлан гаргасан байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжил уламжлалт эдийн засгийн бүтцийг өөрчилж дижитал эдийн засгийг шинээр буй болгож байна. Тиймээс хүн төрөлхтөн дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицоос гадна дижитал ертөнцөд дасан зохих шаардлагатай болов.

ХЯТАДЫН ПАРАДОКС

Хятадын удирдагч Дэн Сяопин (Den Xiaoping) 1982 оны 11 дүгээр сард хуралдсан ХКН-ын XII их хурлыг нээж хэлсэн үгэндээ: «*Марксизмын түгээмэл үнэнийг манай орны тодорхой бодит нөхцөл байдалтай холбож, өөрийн замаар явж, Хятадын онцлогтой социализм байгуулах нь урт хугацааны түүхэн туршлагыг задлан шинжилсэний үндсэн дээр бидний хийсэн гол дүгнэлт юм*» гэжээ. Энэхүү дүгнэлт хийх эргэлтийн цэг нь 1978 оны 12 дугаар сард хуралдсан ХКН-ын ТХ-ны 11 дэх удаагийн Чуулганы III Бүгд хурал болсон юм.

Түүний дэвшүүлсэн эдийн засгийн шинэчлэлийн бодлогын цөм

нь «*нээлттэй хаалга*» байв. Энэ бодлогын үндсэн зорилго нь эдийн засаг, аж ахуйг хөтлөх капиталист үйлдвэрлэлийн аргыг социалист төлөвлөлттэй хоршин нэвтрүүлэхэд оршиж байв. Үүнийг хэрэгжүүлэх эхний хувилбар нь хятадын хямд ажиллах хүч, асар том зах зээлийг гадаадын хөрөнгө оруулалттай нягт уялдуулсан экспортын чиглэлтэй «эдийн засгийн онцгой район», «худалдааны чөлөөт бүс»-ийг буй болгох явдал байжээ.

АНУ-ын нэрт олон улсын тоймч Тед Коппел тайлбарлахдаа: The People's Republic of Capitalism буюу Ардын Бүгд Найрамдах Капитализм хэмээх өнөөгийн БНХАУ-д ХКН 1.4 тэрбум хүн амд бүрэн хүрч ажиллах боломжгүй, тиймийн учир үлдсэн хэсгийг капитализм авч явах учиртай. Үүнийг л Хятадын paradox гэж хэлээд байгаа юм гэжээ.

Хятадын онцлогтой социализмын туршлага бол байнга төвийг сахисан Швейцарь лугаа дахин давтагдашгүй юм. Нөгөө талаар энэ нь марксын сургаалийг орчин үеийн шинэ нөхцөлд баяжуулан хөгжүүлж буй хэрэг гэж хэлж болно. Хятадын онцлогтой социализм, «нэг улс, хоёр систем» үзэл баримтлал бол социалист байгуулалт, гадаад бодлого, олон улсын харилцааны онол, практик, улс төрийн шинжлэх ухааны хөгжилд оруулсан Дэн Сяопины цоо шинэ хийгээд жинтэй хувь нэмэр даруй мөн. Өөрөөр хэлбэл энэ нь социализмын асар их нөөц боломж, түүний давуу талыг нээн харуулж буй явдал юм. Коммунизмын үед хятадын онцлогтой социализмыг маш ихээр шүүмжлэн буруутгаж, марксизм-ленинизмыг хянан засварлаж байна, ХКН бол ревизионист нам гэж нэрлэж байсан. Улс төрийн шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалтын үед М.Горбачев социализм олон хувилбартай, үндэсний онцлогтой байж болохыг хүлээн зөвшөөрсөн. Цөмийн зэвсэгтэй, НҮБ-ын АЗ-ийн хориг тавих эрхтэй байнгын гишүүн, 1.4 тэрбум хүн амтай БНХАУ-ын ДНБ 80 их наяд юань буюу 11.8 их ам. доллар, нэг хүнд ногдох орлого дундажаар 8.4 мянга, харин эдийн засгийн чөлөөт бүсүүдэд 25 мянган ам долларт хүрч, гадаад валютын нөөц 3 их наяд ам. доллар, алтны нөөц 12 мянга 400 тоннд хүрэв. Хүн амын 51 хувь буюу 784 сая иргэн дундаж орлогтой давхаргад шилжив. Энэ нь дундаж анги сүүлийн 10 жилд 2 дахин өссөн үзүүлэлт болж байна. Тэгвэл 2022 онд дундажаас дээгүүр орлоготой чинээлэг

давхарга хүн амын 54 хувь болж, харин дундаж давхарга 22 хувь болж буурах ажээ. Нэг хүнд ногдох орлого дундажаар 16-гаас 34 мянган ам долларт хүрэх ажээ. Өнгөрсөн жилүүдэд жилд 13 сая ажлын байр шинээр нэмэгдэж, 60 сая хүн ядуурлаас гарсан нь Хятадын онцлогтой социализмын давуу талын үр дүн болж байна. Хятадын онцлогтой социализмын үсрэнгүй хөгжил олон улсын харилцааны олон туйлт шинэ дэг тогтолцоог бүрдүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлж байна гэж хэлж болно.

Хятадын удирдагч Ши Жиньпин ХКН-ын XIX их хурлын тайланд тэмдэглэхдээ: Хятадын онцлогтой социализмын шинэ эрин үеийг эхлүүлж байгааг онцолсон. Энэ нь хятадын онцлогтой “хөгжингүй социализм”-ыг байгуулах үе эхэлж байна гэж ойлгож болохоор байна. Шинэ эрин үе 2 үе шаттай хэрэгжих ажээ. ХКН байгуулагдсаны 100 жилийн босгон дээр буюу 1-р үе шат 2020-2035 он өөрөөр хэлбэл эхний 15 жилд чинээлэг нийгмийг бүтээн байгуулах ажээ. Энэ нь дундаас дээгүүр орлоготой чинээлэг социалист нийгэм байх юм. 2-р үе шат 2035-2050 онд “хүчирхэг, ардчилсан, соёлжсон, цэвэрхэн, эв найрсаг, үзэсгэлэнт орчин үеийн аугаа их гүрнийг байгуулах ажээ. Өөрөөр хэлбэл, БНХАУ байгуулагдсаны 100 жилийн босгон дээр хятадын онцлогтой хөгжингүй социализмыг цогцлоон байгуулж дуусна гэсэн үг юм. Энэ нь Хятадын онцлогтой социализмын шинжлэх ухааны онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмэр гэж ойлгож болохоор байна. Үзэсгэлэнт Хятад улсыг цогцлоох гэдэг шинэ томьёолол нь хятад мөрөөдөл бөгөөд байгаль орчинтойгоо дасан зохицож ногоон хөгжлийг хэрэгжүүлнэ гэсэн үг билээ.

Ер нь бол БНХАУ өөрсдийгөө их гүрэн гэдгээс зайлсхийдэг. 1999 оны 6 дугаар сард ХБНГУ-ын Вестфалийн Кельн хотод болсон Их наймын дээд уулзалтад Германы канцлерь Герхард Шрёдер Хятадыг Их наймд нэгдэхийг урьсан байдаг. Өмнөх 1997 оны 6 дугаар сард АНУ-ын Денверт зохиогдсон Их долоогийн уулзалтад Ерөнхийлөгч Б.Клинтон ОХУ-ыг урьж оролцуулснаар Их наймын бүлэг байгуулагдсан байв. Гэвч БНХАУ бол их гүрэн биш гэж үзэж байсан. 2012 оны 11 дүгээр сард хуралдсан ХКН-ын XVIII их хуралд тавьсан улс төрийн илтгэлд ХКН-ын тэргүүн Ху Жинтао: БНХАУ бол дэлхийн хамгийн том хөгжиж буй социалист орон мөн гэж онцлон тэмдэглэж

байсан. Тиймээс олон улсын харилцаанд аль нэг, эсвэл хэсэг бүлэг улс гүрэн жанжлахын эсрэг байр суурьтай байдаг.

ХКН-ын Дүрмийг албан ёсоор ХКН-ын Үндсэн хууль буюу Constitution гэж нэрлэдэг байна. ХКН бол БНХАУ-ыг удирдан чиглүүлэгч улс төрийн манлай дээд хүчин юм. Тиймээс Хятадын онцлогтой социализмын бүтээн байгуулалт хөгжингүй шинэ эрин үедээ орж, гүнзгийрэх тусам ХКН-ын удирдан чиглүүлэх үүрэг роль хэлбэрэлтгүй өсөн нэмэгдэж байна. Социализм, капитализм гүнзгийрэн хөгжих тутам хятадын ард түмний эв нэгдлийг хангах явдал маш чухал болж байна. ЗХУ-д болсон шинэчлэл өөрчлөлт, задрал, арабын хавар Хятадад болсон бол зөвхөн Хятадаар зогсохгүй, бүс нутаг, цаашлаад дэлхий нийтийн хэмжээнд асар том сөрөг үр дагавар үзүүлэх байсан нь тодорхой.

ХКН-ын Үндсэн хуулийн удиртгалд марксизм-ленинизм, Мао Зэдуны үзэл санаа, Дэн Сяопины онолыг дэлгэрэнгүй тэмдэглэснээс гадна, Зян Зэминь, Ху Жинтао нарын хувь нэмрийг ч тэмдэглэсэн байдаг.

Энэ удаагийн ХКН-ын Үндсэн хуулинд орсон шинэ нэмэлтэд нөхөр Ши Жиньпины Хятадын онцлогтой социализмын Шинэ эрин үеийг эхлүүлснийг онцлон тэмдэглээд Ши Жиньпиний үзэл санаа бол марксизм-ленинизм, Мао Зэдуны үзэл санаа, Дэн Сяопины онол, Гурвыг төлөөлөх үзэл санаа, Хөгжлийн шинжлэх ухаанч үзэл санааны шууд үргэлжлэл, түүний хөгжлийн шинэ эрин үе гэж шинээр томъёолсон байна. Гурвийг төлөөлөх үзэл санаа гэдэг нь: *нэгд*, эдийн засгийн үйлдвэрлэлд тулгуурласан тэргүүний нийгмийн үйлдэрлэх хүчнийг төлөөлөх, *хоёрт*, соёлын хөгжилд суурилсан Хятадын тэргүүлэх соёлын дэвшилт чиг шугамыг төлөөлөх, *гуравт*, улс төрийн зөвшилцөлд суурилсан олонхийн язгуур эрх ашгийг төлөөх эдгээр болно. Хөгжлийн шинжлэх ухаанч үзэл санаа гэдэг нь шинлэх ухааны социализм юм.

ХКН-ын үйл ажиллагаа нь ардчилсан төвлөрөн удирдах социалист зарчимд тулгуурладаг. Намын байгууллагуудын бүх шатанд социалист хууль цаазын хэрэгжилтийг тууштай хангах, шударга ёсыг дээдлэх, ялангуяа авилгатай тууштай тэмцэнэ гэжээ. Өнгөрсөн таван жилд 1.4

сая хүн авилгын хэргээр шийтгэгджээ.

БНХАУ-ыг байгуулснаараа Мао Зэдун аугаа юм. Хятадын онцлогтой социализмын архитектор гэдгээрээ Дэн Сяопин аугаа юм. Харин хятадын онцлогтой хөгжингүй социализмын шинэ эрин үеийг эхлүүлж буйгаараа Ши Жиньпин аугаа юм.

2018 оны 3 дугаар сард хуралдсан БХАТИХ-ын 13 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган БНХАУ-ын Үндсэн хуулинд БНХАУ-ын дарга нь дахин нэг удаа улиран сонгогдох тухай заалтыг хасч, Ши Жиньпинд шинэ эрин үеийг дуусгах эрхзүйн боломжийг олгов.

ТӨГСГӨЛ

Ази-Номхон далайн бүс нутагт онцлон Зүүн Азид Япон болон шинээр аж үйлдвэржсэн БНСУ-тай Монгол Улс «гуравдагч хөрш»-ийн бодлогын түвшинд бүх талын харилцаа, хамтын ажиллагааг стратегийн болон иж бүрэн түншлэлийн түвшинд хөгжүүлэхээр тохиролцож, идэвхтэй хамтран ажиллаж байгаа билээ.

Хоёр зууны зааг, гурав дахь мянганы босгон дээр олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцааны төв Ази-Номхон далайн бүс нутагт шилжиж байгаа нь улам бүр илт болов. Сайхь сав нутаг нь байгалийн асар их баялаг, хязгааргүй гүн цэнхэр далай, өргөн уудам тал, элс манхан, хараа цуцам мөнх цаст оргил, байгалийн тансаг унаган дүр төрх, арслан, барс, заанаас аваад аварга том халим загас хүртэл сэтгэл булаам ан амьтан, хүн зоны гайхамшигт өвөрмөц ёс заншил, амьдралын үндэсний хэв жаяг, түүх, соёлын давтагдашгүй өв дурсгал, шинжлэх ухаан, технологийн хачин сонин бүтээл зэрэг энэхүү өнгөлөг өөдрөг бүхэн «*Дорно дахин*» хэмээх нэрийн дор алдаршиж гадна, дотны айлчин гийчний сонирхлыг эртнээс инагш эрхгүй татсаар иржээ. Түүнчлэн энэ бүс нутагт түүхий эдийн эх булаг, капитал оруулах хүрээ, борлуулалтын болон санхүүгийн шинэ зах зээл, шинжлэх ухаан-технологийн хамгийн тэргүүлэх салбарт өрсөлдөөн тэмцэлдээн бүр XIX зууны сүүл үеэс эхэлж, эдүгээ ч үргэлжилсээр буй ажгуу. Германы нэрт гүн ухаанч *К.Маркс* 1850 оны 2 дугаар сард «*Neue Rheinische Zeitung Politisch-ökonomische Revue*» сэтгүүлд нийтлүүлсэн «*Анхны олон улсын тойм*» чансаатай томоохон

өгүүлэлдээ: «*Олон улсын харилцааны аугаа их усан замын үүргийг эртний дэлхий дахинд Газрын Дундад тэнгис гүйцэтгэж байв. Энэхүү үүргийг одоогийн Атлантын далай тээж явна. Чухамдаа ирээдүйд сайхь үүрэг нь Номхон Далайд ногдох болно*»¹⁶ гэж нэгэнтээ урьдчилан тэмдэглэж байжээ. Өрнөдийн судлаачдын тэмдэглэснээр өнгөрсөн зууны сүүлчийн улиралд энэ бүс нутагт том луу (том луу гэдэг нь Хятад, жижиг луу гэдэг нь Хонгконг, Тайвань, Сингапур Д.У) болон Өмнөд Солонгос нойрноосоо аль хэдийн сэрсэн ажээ.

Газарзүйн их нээлтээс үндэс суурь нь тавигдаж, XIX зууны дунд гэхэд сонгодог утгаараа хэлбэршлээ олсон Европын гүрнүүдийн (гол нь Британийн Дорнод Энэтхэгийн компани) шинэ газар нутаг, колони эзэмших геополитиктой уялдан «East», «Eastern» буюу “Дорно”, “Дорно дахины” гэсэн нэр томъёо буй болж, улстөр-газарзүйн үг хэллэгт баттай байраа эзэлжээ. Өрнөд Европт хамгийн дөт орших Энэтхэгээс баруун хойрхи арабын сав нутгийг «Ойрхи дорнод» буюу “Near East”, баруун Азийг «Дундад Дорнод» буюу “Middle East” гэж нэрлэж, заншиж иржээ. Соёл-урлаг, түүх-утга зохиолын бүтээл дор «Дорно дахин»-ыг “Orientalism” хэмээн голдуу нэрлэж ирсэн байх ажгуу. Хятад, Энэтхэгийг бүхэлд нь «Дорно дахин»-д хамааруулж байв.

Харин Сибириэс цааших нутгийг «Far East» буюу “Алс Дорнод”, «Far Eastern» буюу “Алс Дорно дахины” хэмээн нэрлэсээр иржээ. Сайхь бүс нутагт Оросын Европын хэсгээс цааших Алс Дорнодын сав, Солонгосын хойг, Япон, Монгол, Манж Чин гүрний Зүүн хойд хэсгийг хамруулж, энэ нь аанай л геополитик-газарзүйн шинжлэх ухааны нэгэнт тогтсон нэр томъёо болов. Гэхдээ Монголын талаас авч үзвэл Өрнө дахин, Ойрхи Дорнод нь Алс Дорно дахин бөгөөд харин Алс Дорно дахин нь Ойрхи Дорнод мөн билээ.

Өрнө дахины хувьд XIII-XIV зуунд Дорно дахины зүгээс Монголчууд гол аюул заналыг учруулж, Евразийг бүхэлд нь эрхшээл, нөлөөндөө оруулж агсан ахул харин XIX зууны сүүлч гэхэд Дорно дахин нь өөрөө Японыг эс тооцвол бүхэлдээ Өрнө дахины колони, хараат нутаг дэвсгэр болж байсан билээ.

XX зууны эхээр В.И.Ленин Дорно дахины дарлагдсан улс түмний өөртөө засан тогтнох эрхийн тухай, үндэстэн ба колонийн асуудлаар улам бүр цогтой дуугарах болж, орчин үеийн ирээдүйн социалист хувьсгал дахь *Дорно дахины сэргэлтийн дараа* тэдгээр ард түмэн зөвхөн түүхий эд нийлүүлэгч, баяжуулагч байхаа больж дэлхийн хувь заяаг шийдвэрлэхэд оролцох үе эхэлж байна гэж хөөрөгдүүлж байв. Өрнө дахины капитализмыг нэг мөр буулгаж авахад дэлхийн хувьсгалын галыг асаах, юуны өмнө тэдний колони Дорно дахины орнуудад большевизмыг түгээн дэлгэрүүлэх явдал үүний гол эх сурвалж болж байсан юм.

XIX-XX зууны заагт Алс Дорно дахин хэмээн нэгэнт нэрлэгдэх болсон сайхь бүс нутагт их гүрнүүдийн хүчний тэнцвэрт үндсэн өөрчлөлт орсноор олон улсын харилцааны шинэ дэд бүтэц нэгэнт бүрэлдэн тогтов. Энэ түүхэн үед XX зууны эхээр Монгол Улс Чин гүрний олон жил үргэлжилсэн эзэн эрхийг эцэс болгож, тусгаар тогтнол юугаан сэргээн тунхаглаж, олон улсын харилцааны түүхийн тавцан дээр дахин цойлон гарч ирсэн бөлгөө. Цаашилбал гол нь гадаад хүчин зүйлсээс шалтгаалж, Монголчуудын тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд баталгаажуулах хүчин чармайлт XX зууны туршид үргэлжилсэн юм. Харин энэ их үйлсийн биелэл жинхэнэ утгаараа хүйтэн дайны төгсгөл үед тохиов. 1990-ээд оноос Монгол Улс үндэсний язгуур эрх ашгаа дээдэлсэн, олон тулгуурт, нээлттэй, энхийг эрхэмлэсэн, үл нэгдэх, бие даасан гадаад бодлого явуулсан нь Дорно, Өрнийн олон шинэ түншүүдтэй учруулав.

Монгол Улс шинээр аж үйлвэржсэн «Азийн бар» Өмнөд Солонгос улстай дипломат харилцаа тогтоосны дараа удалгүй 1990 оны намар БНМАУ-ын анхны бөгөөд сүүлчийн Ерөнхийлөгч П. Очирбат «Монгол Улс ойрын 5-6 жилийн дараа “Азийн бар” орон болно» хэмээн сүр дуулиантай мэдэгдсэн билээ.

16 Karl Marx. Neue Rheinische Zeitung. Politisch-ökonomische Revue. February 1850